



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/554

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а”, Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Засгийн газрын 2017 оны 69 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд “Ангиртын гурван булаг” ХХК-ны хийж гүйцэтгэсэн “Холбооны шугам сүлжээг шинэчлэн засварлах /Жаргалант сум/” ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Ганзориг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Алтанхуяг - “Мэдээлэл холбоо сүлжээ” ТӨХХК-ний Ховд аймгийн газрын ерөнхий инженер

П.Азжаргал - “Мэдээлэл холбоо сүлжээ” ТӨХХК-ний Ховд аймгийн газрын кабель шугамын инженер

Б.Бурмаа - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Ц.Сувдаа - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

D/Zax-A/554-Da

00 02739

2. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд “Ангиртын гурван булаг” ХХК-ний хийж гүйцэтгэсэн “Холбооны шугам сүлжээг шинэчлэн засварлах /Жаргалант сум/” ажлыг ажлын даалгавар, тоо хэмжээний дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргаж хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч /Н.Ганзориг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН